



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 08 сарын 02 өдөр

Дугаар А/382

Ховд

Баруун бүсийн хурдан морьдын
уралдаан зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6, 29.28 дахь заалт, Улсын Онцгой комиссын 2021 оны 7 дугаар сарын 23-ны өдрийн 25 дугаар хуралдааны шийдвэр, аймгийн Онцгой комиссын 2021 оны 7 дугаар сарын 28-ны өдрийн 52 дугаар тогтоол, Аймгийн морин спорт уяачдын "Алтайн унага" холбооны хүсэлтийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Баруун бүсийн хурдан морьдын уралдааныг үзэгчгүйгээр 2021 оны 8 дугаар сарын 06, 07, 08-ны өдрүүдэд Буянт сумын нутаг Цалуугийн дэнж /Бөөр хар/-д зохион байгуулсугай.

2. Баруун бүсийн хурдан морьдын уралдаан зохион байгуулах комиссыг байгуулж, хурдан морьдын уралдааныг "Монголын хурдан морьдын уралдааны дүрэм", холбогдох хууль, тогтоомж, журмын дагуу Улс, аймгийн Онцгой комиссын шийдвэр, чиглэл, коронавируст халдвар /Ковид-19/-аас урьдчилан сэргийлэх, халдвар хамгааллын дэглэмийн журам, зааврыг чанд мөрдөн тогтоосон хугацаанд үзэгчгүйгээр хариуцлагын гэрээний дагуу өндөр түвшинд зохион байгуулахыг уралдаан зохион байгуулах ажлын хэсэг /Б.Ерөөлт/-т даалгасугай.

3. Хурдан морьдын уралдаан зохион байгуулахад коронавируст халдварт /Ковид-19/ цар тахлаас урьдчилан сэргийлэх, халдвар хамгааллын дэглэм мөрдөх ерөнхий болон тусгай журам, зааврын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн газар /Ц.Мягмарсүрэн/, Цагдаагийн газар /цагдаагийн хурандаа Э.Даваасүрэн/, Мэргэжлийн хяналтын газар /П.Эрдэнэчулуун/, Мал эмнэлгийн газар /Ц.Батцэнгэл/, "Ховд аймгийн авто тээврийн төв" улсын үйлдвэрийн газар /Н.Ирэхзаяа/ нарт үүрэг болгосугай.


4. Тус уралдаанд оролцогч унаач хүүхдүүдээс коронавируст халдвар /Ковид-19/-ын хурдавчилсан тестээр шинжилгээ авч, унаач хүүхдүүдийн эрүүл мэнд, амь нас, аюулгүй байдлыг бүрэн ажиллахыг Эрүүл мэндийн газар /Ц.Мягмарсүрэн/, Бүсийн оношилгоо эмчилгээний төв /П.Гэрэлсүрэн/, Гэр бүл, хүүхэд залуучуудын газар /Ц.Номинчимэг/, Цагдаагийн газар /цагдаагийн хурандаа Э.Даваасүрэн/, Мэргэжлийн хяналтын газар /П.Эрдэнэчулуун/ нарт даалгасугай.

5. Хурдан морьдын уралдааны үед иргэд, тээврийн хэрэгслийн хөдөлгөөн, нийтийн хэв журам сахиулах арга хэмжээг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Цагдаагийн газар /цагдаагийн хурандаа Э.Даваасүрэн/-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ



БАРУУН БҮСИЙН “МОРИН УРАЛДААН” СПОРТЫН АРГА
ХЭМЖЭЭНИЙ ХУРДАН МОРИНЫ УРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

- Дарга: Б.Ерөөлт - “Алтайн унага” морин спорт уяачдын холбооны тэргүүн
- Ц.Бат-Эрдэнэ - “Алтайн унага” морин спорт уяачдын холбооны тэргүүлэгч
- Б.Ганзориг - “Алтайн унага” морин спорт уяачдын холбооны тэргүүлэгч
- Б.Баатарбилэг - “Алтайн унага” морин спорт уяачдын холбооны тэргүүлэгч
- Ц.Энхболд - “Алтайн унага” морин спорт уяачдын холбооны тэргүүлэгч
- Д.Хүрэлбаатар - “Алтайн унага” морин спорт уяачдын холбооны тэргүүлэгч
- С.Ганхуяг - “Алтайн унага” морин спорт уяачдын холбооны тэргүүлэгч
- У.Пүрэвдорж - “Алтайн унага” морин спорт уяачдын холбооны тэргүүлэгч
- Т.Эрдэнэбаатар - “Алтайн унага” морин спорт уяачдын холбооны тэргүүлэгч
- М.Ганзориг - “Алтайн унага” морин спорт уяачдын холбооны тэргүүлэгч
- Т.Баярсайхан - “Алтайн унага” морин спорт уяачдын холбооны тэргүүлэгч
- П.Эрдэнэ-Очир - “Алтайн унага” морин спорт уяачдын холбооны тэргүүлэгч
- Нарийн бичгийн
дарга: Д.Батхуяг - “Алтайн унага” морин спорт уяачдын холбооны тэргүүлэгч